


МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Бид хичээлийн шинэ жил эхлэхээр ангийн хурал хийдэг шүү дээ. Яг түүн шиг Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дараа **Анхдугаар чуулганыг** зохион байгуулдаг.

Анхдугаар чуулганаар УИХ-ын гишүүд УИХ-ын даргыг сонгох, хуралдааны дэгээ батлах, Засгийн газар байгуулах зэрэг асуудлыг шийдвэрлэж, Улсын Их Хурлын гишүүд тангаргаа өргөдөг.



Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь **ЧУУЛГАН** байна.

- ✓ УИХ-ын үйл ажиллагаа хуулиар тогтоосон хуралдааны дэгийн дагуу явагддаг.
- ✓ Энэхүү хуралдааны дэгийг Улсын Их Хурал өөрөө тогтоох ба гишүүд дагаж мөрдөх үүрэгтэй.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАН нь нэгдсэн хуралдаан, байнгын, түр, дэд хорооны хуралдаан, нам эвслийн бүлэг, ажлын хэсгийн хуралдаанаас бүрдэнэ.





Улсын Их Хурлын ЭЭЛЖИТ ЧУУЛГАН жилд хоёр удаа хуралдана.

Намрын чуулган жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдрөөс, Хаврын чуулган 3 дугаар сарын 15-ны өдрөөс тус тус эхлэн 75-аас доошгүй ажлын өдөр хуралддаг.



Улсын Их Хурлын гишүүн нь намрын болон хаврын чуулганд оролцож Монгол Улсад тулгамдаж байгаа бодлогын асуудлыг шийдэж, хууль батлах үйл ажиллагаанд оролцоно.

Нэгдсэн хуралдаан долоо хоног бүрийн **пүрэв, баасан гарагт** нийтэд нээлттэй хуралдана.

Энэ бол УИХ-ын Чуулганы НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТАНХИМ



Уг танхимын хойморт байрлах 3 суудлын төвд нь Улсын Их Хурлын дарга, түүний баруун гар талд нь Монгол Улсын Ерөнхийлөгч, зүүн гар талд нь Монгол Улсын Ерөнхий сайд суудаг.



76 гишүүний суудлын баруун гар талд ОЛОНХ сууна. Олонх гэдэг нь сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 39, эсхүл түүнээс олон суудал авсан нам, эвслийн бүлгийг хэлнэ.



76 гишүүний суудлын зүүн талд ЦӨӨНХ сууна. Цөөнх гэж сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 38, эсхүл түүнээс цөөн суудал авсан нам, эвслийн бүлэг, гишүүнийг хэлнэ.




Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга бол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн зөвлөх юм.

Байнгын хороо нь хуулийн төслийг урьдчилан хэлэлцэж **санал, дүгнэлт** гаргах үүрэгтэй.

Байнгын хороог **боловсрол, хууль зүй, ёс зүй, байгаль орчин, нийгэм болон эдийн засаг** гэх мэт салбараар байгуулдаг.

Байнгын хороо долоо хоног бүрийн **мягмар, лхагва гарагт** хуралдана.




Нэг нам, эвслээс нэр дэвшсэн найм, эсхүл түүнээс дээш тооны хүн УИХ-ын гишүүнээр сонгогдсон бол тэдгээр гишүүд нам, эвслийн бүлэг байгуулж болно. Намууд хамтарч сонгуульд оролцохоор нэгдэж "Эвсэл" байгуулдаг. УИХ-ын гишүүд **намын бүлэг, эвслийн бүлгээрээ** хуралдаж асуудал хэлэлцдэг.

Улсын Их Хурал асуудлыг ямар ч нөхцөлд хуралдаанаар хамтран хэлэлцэж, цөөнхийн байр суурийг хүндэтгэж, олонхын саналаар шийдвэрлэнэ. Гишүүн ганцаараа эцсийн шийдвэр гаргахгүй бөгөөд түүний санал нь **76 гишүүний саналын нэг** байна.

ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

УИХ-ын ээлжит чуулганы чөлөө цагт Ерөнхийлөгч онц болон дайны байдал зарлавал түүнээс хойш 72 цагийн дотор УИХ-ын гишүүд яаралтай хуралддаг чуулганыг **ОНЦГОЙ ЧУУЛГАН** гэнэ.

Монгол Улсын түүх, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалтай салшгүй холбоотой түүхэн ой, үйл явдлыг тэмдэглэх, түүнчлэн гадаад улсын өндөр дээд зочин нэгдсэн хуралдаанд үг хэлэх бол **ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААН** зарлан хуралдуулдаг.



ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН - Ээлжит чуулганы чөлөө цагт УИХ-ын 25-аас дээш гишүүний шаардсанаар эсхүл Ерөнхийлөгч, УИХ-ын даргын санаачилгаар хуралдуулж болно.



ТҮЛХҮҮР ҮГ




- ✓ Чуулган
- ✓ Анхдугаар чуулган
- ✓ Ээлжит чуулган
- ✓ Ээлжит бус чуулган

- ✓ Онцгой чуулган
- ✓ Хүндэтгэлийн хуралдаан
- ✓ Байнгын хороо
- ✓ Хуралдааны дэг



ДАСГАЛ АЖИЛ



Мини парламентын хуралдааныг зохион байгуулцгаая.

Танай ангийг "Улсын Их Хурал" байна гэж төсөөлье. Ангийн сурагчид дундаасаа УИХ-ын даргыг сонгоно. Дараах Байнгын хороог байгуулна. Үүнд:

- ✿ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо;
- ✿ Эдийн засгийн байнгын хороо;
- ✿ Хууль зүйн байнгын хороо.

Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар "Хийжүүлсэн ундааг худалдаалахыг хориглох тухай" асуудлыг хэлэлцэнэ.



ХЯНАЛТЫН АСУУЛТ



1. Чуулган гэж юу вэ?
2. Чуулганы төрлүүдийг нэрлэж, тайлбарлана уу.
3. Улсын Их Хурлын үйл ажиллагааны зураглалыг гаргаарай.
4. Улсын Их Хурал хэрхэн ажилладаг вэ? Улсын Их Хурлын Байнгын хороо болон нэгдсэн хуралдааны уялдаа холбоог тайлбарлана уу.